

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Мон Атом ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/100/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	8
	2.8.2. Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .	9
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.21 № 06/548
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон Атом ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мон Атом ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мон Атом ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Мон Атом ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Мон Атом ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Мон Атом ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардлын бүртгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон Атом ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Мон Атом ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Мон Атом ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 14-нөөс 2019 оны 3 дугаар сарын 1-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Мон Атом ХХК-ийн гүйцэтгэх захиралд хүргүүлэхээр төлөвлөн, “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Мон Атом ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/39 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мон Атом ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мон Атом ХХК нь Ашигт малтмалын тухай хууль болон цөмийн энергийн тухай хуулийн дагуу Монгол улсын нутаг дэвсгэрт Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элментийн эрэл, тандан судалгаа, хайгуулын ажлыг гүйцэтгэн нөөцийг тогтоох, тэдгээрийг олборлох, ашиглах, цөмийн түлш, эрчим хүчний үйлдвэрлэл эрхлэх, тэдгээрт шаардлагатай материаллаг бааз болон үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, энэ салбар дахь гадны болон хувийн хөрөнгө оруулалттай төслүүдийг Монгол улсад хэрэгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилго тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Мон Атом ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралтаар Мон Атом ХХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг тогтоож, түүнийг өсгөн нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулах,
- Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, боловсруулах
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд нийлүүлж ,борлуулах,
- Атомын цахилгаан станцад хэрэглэгдэх цөмийн түлшний циклийн зөвшөөрөгдсөн шат дамжлагыг бий болгон хөгжүүлэх,
- Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлогын дагуу цөмийн эрчим хүчийг ашиглах, хүчин чадлыг бий болгох санал, үндэслэл боловсруулж , хэрэгжилтийг хангах,
- Уран, цөмийн эрчим хүчтэй холбогдсон асуудлуудаар гадаад орон, тэдгээрийн компаниудтай бүх төрлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх,

- Салбарын чиглэлийн олон улсын, улс хоорондын мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах,
- Уран, цөмийн эрчим хүчний судалгаа, шинжилгээ эрхэлж, үндэсний боловсон хүчнийг бэлтгэж, сургах,
- Үйлдвэрлэл, үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээх ажил хийх,

Мон Атом ХХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мон Атом ХХК-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төрийн өмчит байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Иргэний хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Сангийн сайдын 2011 оны 12 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын хайгуулын болон, ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журам”
- Санхүүгийн тайлангийн хайгуул, үнэлгээний хөрөнгө СТОУС-6

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мон Атом ХХК-ийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Мон Атом ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мон Атом ХХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “бааз” програм хангамж ашигладаг байна.

Мон Атом ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мон Атом ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үйл ажиллагааны нийт зардлыг сонгов.

Үйл ажиллагааны нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь үйл ажиллагааны орлого бага, зардлын данстай холбоотой эрсдэл их, өмнөх онуудад материаллаг байдлын суурийг нийт зардлыг сонгосныг харгалзан үзэж үйл ажиллагааны нийт зардлыг материаллаг байдлын сууриар сонгон авлаа.

Мон Атом ХХК-ийн 2018 оны үйл ажиллагааны нийт зардлын дүн 849.8 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 17.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 9 асуудлыг алдаа,

зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Мон Атом ХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Ажилчиддаа тушаал шийдвэргүй 72.0 сая төгрөгийн цалингийн нэмэгдэл олгосныг хөдөлмөрийн хууль, байгууллагын дотоод журмын дагуу байгууллагын тушаал, шийдвэрийг гаргуулав.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/сая төгрөгөөр/ Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	14.4	
2	Албан шаардлага өгсөн	1	1.2	
	Дүн	5	15.6	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Захиргааны чөлөө авсан ажилтанд хоол, унааны 0.1 сая төгрөгийн нэмэгдэл цалин олгосон. Мөн захиргааны чөлөө авсан ажилчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо чөлөөтэй байх хугацааны цалин болох 1.1 сая төгрөгийг дундаж цалинд оруулж бодсон. Нийт 1.2 сая төгрөгийн алдаа, зөрчил үүссэн.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор зөрчлийг арилгах үүргийг албан шаардлагаар хүргүүлсэн.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. 2013 онд Чех Улсаас авсан 2.2 сая ам.доллар буюу 5,682.3 сая төгрөгийн зээлийн хэрэгжилтэнд хяналт тавих.

2. “Мон зим интернейшнл” ХХК-наар 2013 онд хийлгэсэн хайгуул үнэлгээний хөрөнгө 1,927.2 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг хянах.

3. Урт хугацаат хөрөнгө оруулалт 1,575.2 сая төгрөг байна. Энэ нь “Бадрах энерги” ХХК, “Гурван сайхан” ХХК, “Төв азийн уран” ХХК эдгээр 3 компаниудын хувьцааг хөрөнгө оруулалт хэлбэрээр Мон Атом ХХК-д эзэмшүүлсэн.

4. “Мон зим интернейшнл” ХХК-тай хийх 216.1 сая төгрөгийн өглөгийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулах.

5. “Эрдэнэс Монгол” ХХК-наас авсан санхүүжилтанд хүү тооцдог. Энэ асуудлыг “Эрдэнэс монгол” ХХК-тай тохиролцож, хуулийн дагуу шийдвэрлэх.

6. Тээврийн зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс 15.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн. Энэ нь тус байгууллагын гүйцэтгэх захирал соната маркын автомашин унахаар зардлыг төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр Засгийн газрын авто баазаас шатахуун их зарцуулдаг жийп автомашин түрээсэлснээс үүдэлтэй байна.

7. Мон Атом ХХК нь 2018 онд ажилтнуудад ажлын ачаалал нэмэгдээгүй алдагдалтай ажиллаж байгаа боловч ажилтан бүрт 0.5 сая төгрөгийн цалин нэмснээс үүдэн алдагдлыг 72.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

8. 81.1 сая төгрөгийн цалингийн өглөгийг шүүхэд хандан шийдвэрлүүлэх.

9. Нэмэгдсэн өртгийн албан татварын 104.6 сая төгрөгийн авлагыг холбогдох татварын байгууллагатай тооцоо нийлж дуусгах.

2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлага нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мон Атом ХХК-ийн үйл ажиллагаанд зориулан 2018 онд 640.7 сая төгрөгийн зардлын төлөвлөгөө батлагджээ. Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төлөвлөгөөт зардлын нийт гүйцэтгэл 501.9 сая төгрөг буюу 78.3 хувьтай байна. 2018 онд нийт төлөвлөгөөт зардлыг 138.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Зардлыг хэмнэсэн гол шалтгаан нь байрны түрээсийн зардал төлдөггүйтэй холбоотой юм.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мон Атом ХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод, хугацаанд нь мэдээллэдэг.

Мон Атом ХХК нь шилэн дансанд дараах 5 мэдээллийг оруулдаг байна.

- Концесын гэрээ
- Хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг объект тус бүрээр
- Худалдан авах ажиллагаа, тендэртэй холбоотой мэдээллийг тухай бүр
- Бонд, зээл, өрийн бичиг, өр авлагыг үүсгэсэн шийдвэр гарсан тухай бүр
- 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6 зөвлөмжийн 5 зөвлөмжийг биелүүлж, 1 зөвлөмжийг биелүүлээгүй гэж үзэж байна. Үүнд:

Томилолтоор ажилласан албан хаагч нар дараа тайлангаар авсан мөнгөний зарцуулалтыг бүрэн гаргадаггүй байна.

Энэхүү зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мон Атом ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мон Атом ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мон Атом ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой:

1.1 Илрүүлэлт:

Худалдан авсан шатахууны зарцуулалтыг тооцдоггүй, жолоочийн замын хуудас хөтөлдөггүй, 3.2 сая төгрөгийн шатахууныг шууд зардалд тооцсон.

1.2 Батламж мэдэгдэл:

Энэ нь “иж бүрэн байх, хэмжилт ба тохиолдсон, үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д зааснаар “ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.3 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 дүгээр заалт хэрэгжихгүй байх эрсдэлтэй.

1.4 Өгсөн зөвлөмж:

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтыг тухай бүр замын хуудас бичиж, холбогдох ажилчдаар гарын үсэг зуруулж, тооцоо бодож байх.

1.5 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллана.

2. Татварын данстай холбоотой:

2.1 Илрүүлэлт:

Урамшууллын цалингаас хувь хүний орлогын албан татвар болох 0.6 сая төгрөгийг суутган аваагүй байна.

2.2 Батламж мэдэгдэл:

Энэ нь “тохиолдсон байх ба эрх үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1-д “албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараахь орлогод албан татвар ногдуулна”, 8.1.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого” гэсэн заасан заалтыг баримталж ажиллаагүй байна.

2.3 Эрсдэл:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дүгээр заалт хэрэгжихгүй байх.

2.4 Өгсөн зөвлөмж:

Цаашид Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1 дүгээр заалтыг мөрдөж ажиллах, тус ажилчнаас татварыг суутган авч холбогдох төсөвт шилжүүлэх.

2.5 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, цаашид хууль дүрмийг мөрдөж ажиллана.

3. Зардлын данстай холбоотой:

3.1 Илрүүлэлт:

Ажилчиддаа тэтгэмж олгохдоо байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хэмжээг 0.6 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон.

3.2 Батламж мэдэгдэл:

Энэ нь “хэмжилт, тохиолдсон байх ба эрх үүрэг, үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн байна.

3.3 Эрсдэл:

Тэтгэмжийг хууль тогтоомж, дотоод дүрэм, журмаас илүү тогтоосон, цалингийн зардал хэтрэх эрсдэлтэй.

3.4 Өгсөн зөвлөмж:

Цаашид холбогдох хууль, дүрэм, заавар, журмыг мөрдөж ажиллах, төсвийг хэмнэн ажиллах.

3.5 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, цаашид хууль дүрмийг мөрдөж ажиллана.

4. Зардлын данстай холбоотой:

4.1 Илрүүлэлт:

Албан томилолтын тооцоо хийж, тайлан гаргадаггүй. Дараа тайлан гаргахаар авсан 10.0 сая төгрөгийн бэлэн мөнгөний зарцуулалтын анхан шатны баримтыг бүрдүүлээгүй буюу дутуу бүрдүүлсэн.

4.2 Батламж мэдэгдэл:

Энэ нь “иж бүрэн байх, тохиолдсон байх ба эрх үүрэг, бодитой оршин байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ын тухай хуулийн 7.7 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.3 Эрсдэл:

Энэ нь зардлыг буруу бүртгэх эрсдэлтэй.

4.4 Өгсөн зөвлөмж:

Цаашид холбогдох хууль, дүрэм, заавар, журмыг мөрдөж ажиллах, анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллах.

4.5 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, цаашид анхааран ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,904,190.36	7,301,696.55
1.1.2	Дансны авлага	2,500,000.00	1,200,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	97,935,206.06	104,630,915.91
1.1.4	Бусад авлага	2,069,981.82	4,691,580.82
1.1.6	Бараа материал	381,714.88	1,659,801.60
	Эргэлтийн хөрөнгийн дүн	113,791,093.12	119,483,994.88
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	27,807,461.73	40,069,269.50
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,575,192,180.00	1,575,192,180.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1,927,177,212.00	1,927,177,212.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,530,176,853.73	3,542,438,661.50
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,643,967,946.85	3,661,922,656.38
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,946,252,006.24	3,008,345,393.08
2.1.1.2	Цалингийн өглөг	172,075,872.95	81,082,307.75
2.1.1.3	Татварын өр	73,546,957.62	47,648,508.40
2.1.1.4	НДШ–ийн өглөг	194,730,412.53	170,353,173.16
2.1.1.5	Богино хугацаат зээл	399,999,995.00	94,980,935.00
2.1.1.6	Хүүний өглөг	456,356,123.61	790,400,749.51
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,242,961,367.95	4,192,811,066.90
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	5,218,329,500.00	5,682,278,000.00
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,218,329,500.00	5,682,278,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8,461,290,867.95	9,875,089,066.90
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	100,000,000.00	100,000,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,575,192,180.00	1,575,192,180.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-6,492,515,101.10	-7,888,358,590.52
2.3.11	Эздийн өмчийн дүн	-4,817,322,921.10	-6,213,166,410.52
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,643,967,946.85	3,661,922,656.38

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	29,508,600.00
2	Борлуулалтын өртөг	-	24,523,309.69
3	Нийт ашиг(алдагдал)	-	4,985,290.31
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	144,573.22	927,502.22
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	41,425.78	20,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	10,500.00
11	Санхүүгийн зардал	361,355,334.66	515,593,863.15
12	Бусад зардал	288,788,848.53	334,171,979.46
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	236,105,772.14	88,066,438.90
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	134,155,010.75	-463,933,500.44
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-751,908,945.58	-1,395,843,489.42
19	Орлогын татварын зардал	14,457.32	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-751,923,402.90	-1,395,843,489.42
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-751,923,402.90	-1,395,843,489.42
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-751,923,402.90	-1,395,843,489.42
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	1,575,192,180.00	-5,714,485,160.03	-4,039,292,980.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	1,575,192,180.00	-5,714,485,160.03	-4,039,292,980.03
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-778,029,941.07	-778,029,941.07
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	1,575,192,180.00	-6,492,515,101.10	-4,817,322,921.10
9	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	1,575,192,180.00	-6,492,515,101.10	-4,817,322,921.10
10	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /			-1,395,843,489.42	-1,395,843,489.42
11	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	1,575,192,180.00	-7,888,358,590.52	-6,213,166,410.52

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	41,425.78	58,975,522.56
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	58,940,523.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	41,425.78	34,999.56
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,043,310,509.52	724,483,828.56
1.2.1	Ажиллагчдад төлсөн	509,419,078.76	349,255,413.40
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	122,088,842.00	113,021,872.37
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,642,089.80	16,279,794.58
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,848,254.54	4,788,119.73
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,503,470.01	17,714,423.36
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	66,771,853.00	55,870,317.50
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	98,010.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	328,938,911.41	167,553,887.62
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,043,269,083.74	-665,508,306.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,411,099.22	1,927,502.22
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,266,526.00	1,000,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	144,573.22	927,502.22
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	22,252,604.73	100,621,532.69
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	327,254.55	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	21,925,350.18	100,621,532.69
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-20,841,505.51	-98,694,030.47
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,154,409,865.00	1,065,745,956.22
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн	1,154,409,865.00	1,065,745,956.22

Мон Атом ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	80,188,919.79	305,146,113.56
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	80,188,919.79	305,146,113.56
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,074,220,945.20	760,599,842.66
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	10,110,355.95	-3,602,493.81
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	793,834.41	10,904,190.36
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,904,190.36	7,301,696.55

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Шалгагдсан байгууллагын нэр:	Мон Атом ХХК	Аудитын код:	САГ-2019/100/СТА-ТӨҮГ
Аудитын нэр:	Мон Атом ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Сая төгрөгөөр	

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөн гөн дүн	Аудитын байгуулл агаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах албан тушаалтны	
						Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	9	10
1	Зардлын данстай холбоотой	1	Захиргааны чөлөө авсан ажилтанд хоол, унааны нэмэгдэл олгосон. Мөн захиргааны чөлөө авсан ажилчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо тэтгэмжтэй чөлөөтэй байх хугацааны цалинг дундаж цалинд оруулж бодсон.	1.2	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогч	Д.Далайжаргал, Д.Батзаяа
2	Зардлын данстай холбоотой	1	Худалдан авсан шатахууны зарцуулалтыг тооцдоггүй, жолоочийн замын хуудас хөтөлдөггүй, шатахууныг шууд зардалд тооцсон.	3.2	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Батзаяа
3	Татварын данстай холбоотой	1	Урамшууллын цалингаас хувь хүний орлогын албан татвар суутган аваагүй байна.	0.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Батзаяа
4	Зардлын данстай холбоотой	1	Ажилчиддаа тэтгэмж олгохдоо байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хэмжээг хэтрүүлэн олгосон.	0.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Батзаяа
5	Зардлын данстай холбоотой	1	Албан томилолтын тооцоо хийж, тайлан гаргадаггүй. Дараа тайлан гаргахаар авсан мөнгөний зарцуулалтын анхан шатны баримтыг бүрдүүлээгүй буюу дутуу бүрдүүлсэн.	10.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогч	Д.Далайжаргал, Д.Батзаяа
Дүн				15.6			